

## Аюулаас хол бай

Дафа төгсгөлийн эцсийн цаг үед хүмүүсийг аврахаар энд байна, Дафа бол бясалгал. Хэдийгээр зарим хүмүүс Дафа-гийн шавь нарын орчинд байдаг ч тэд үнэндээ жинхэнэ бясалгалд ороогүй байдаг, гол мөчид тэд үргэлж хүний сэтгэлээр, хүний бодлоор болон хүний сэтгэл хөдлөлөөр асуудалд ханддаг, тэр ч байтугай “Би Дафа-гийн төлөө ийм тийм зүйл хийсэн, Би Дафа-д маш их хувь нэмэр оруулсан” гэх мэтээр ярьдаг. Ийм хүмүүс ХКН-ын хорон туршуулуудад ашиглагдахад хамгийн амархан байдаг.

Дафа бол угаасаа байдаг, төгсгөлийн эцсийн цаг үед хүмүүсийг аврахын тулд хүний ертөнцөд илэрсэн. Дафа-гийн төлөө “Хүн” юу хийж чадна вэ? Энэ бол Дафа “хүнийг” аварч байна! "Хүн" Дафа-гийн төлөө ямар нэгэн зүйл хийж байгаа юм биш! Бясалгалын явцад "хүн" шударга бус байдлын улмаас зовж, хорон муугийн хавчлагад хэлмэгдэж байхад Багш чамайг хамгаалахын зэрэгцээ чиний өмнөөс нүгэлт үйлийн үрийг чинь үүрч байдаг. Багш чамд ямар ч өргүй! Багш та нарыг аварч байгаагийнхаа төлөө хорон муу ХКН-ын гүтгэл доромжлолыг хүлээж байдаг. Чиний төрөл төрөлдөө тавьсан өрийн авлагын эзэд, тэр ч байтугай чиний асар их нүгэлт үйлийн үрийн хохирогчид хүртэл чамайг өрөө төлөхийг зайлшгүй шаардана, яах болж байна? Орчлон ертөнцийн Фа зарчим бас хүн бүрийг цэгнэдэг, тийм учраас бясалгалын явцад зовлон зүдүүр тохиолдох болно, мөн яагаад хавчлага хэлмэгдэлд өртөж байгаагийн учир нь энэ юм. Хавчлага хэлмэгдлийн үед чи сайн хийж чадаагүйгээс зовлон зүдүүрийг улам ширүүсгэдэг. Чи даван туулж чадахгүйдээ Дафа-д гомдоллодог, зарим нь бүр Багшид гомдоллодог. Энэ бол чамд өөрт чинь асуудал байгаагийнх, Багш чамд ямар ч өргүй. Багш чамайг аврахын зэрэгцээ чиний төлөө нүглийг чинь үүрч, чиний үйлийн үрийг барагдуулахын тулд бүх аргыг бодож олдог, энэ бол чи Багшдаа өртэй. Чи Дафа болон хавчлагын талаар үнэнийг таниулахад тусалснаа, Дафа-гийн үйл ажиллагаанд болон Дафа-гийн төсөлд оролцсоноо, Дафа эсвэл Багшийн төлөө аливааг хийсэн гэж бүү бод. Энэ бол Багш та нарыг харилцан бие биенээ аврах, хамтдаа хүмүүсийг аврахын зэрэгцээ өөрсдийгөө аврахыг хэлж байгаа юм, энэ бол төгсгөлийн эцсийн цаг үед амь бодиуд бие биендээ авралыг олоход нь тусалж байна. Энэ бол Дафа-гийн төлөө хийж байгаа зүйл биш. Дафа анхнаасаа оршин байсан, үүнд хэн ч нөлөөлж чадахгүй. Төгсгөлийн үед Дафа хүмүүсийг аврахаар энд ирсэн, эс бөгөөс хүмүүс орчлон ертөнцөд Дафа байдаг гэдгийг мэдэх ч үгүй байх байсан.

Дафа-гийн шавь нарын үнэнийг таниулах зорилго нь өөрсдийгөө төгс төгөлдөрт хүргэхийн зэрэгцээ зовлон бэрхшээлийн дунд өөрсдийгөө хатуужуулж үйлийн үрээ арилгах явдал юм. Энэ нь бясалгалыг илүү утга учиртай, бүр агуу болгодог. Энэ нь бас Дафа-гийн төлөө хийж байгаа юм биш, харин бясаллагчид өөрсдийнхөө төлөө хийж байгаа юм. Мөрдлөг хавчлагын үед туулж байгаа хэлмэгдэл, шударга бус байдал нь мөн чиний үйлийн үрийг арилгаж байгаа юм, Дафа-гийн төлөө тэсвэрлэж байгаа хэрэг биш, тэр тусмаа Багшийн

төлөө биш! Дафа бүх амь бодиудыг аврахаар энд ирсэн, чи мөн багтана! Чамайг авраад чамд өртэй болж болох уу? Төгсгөлийн үеийн задрал мөхлөөс өмнө өөрийнхөө төлөөлж буй амь бодиудыг аврахын тулд хүний ертөнцөд ирж Дафа-д бясалгах хүсэлтэйгээ илэрхийлэн гэрээнд гарын үсэг зурахыг чи өөрөө хүссэн. Өөрөөр хэлбэл, чи Дафа-гийн шавь болох, Дафа-гаар бясалгахын тулд амиараа дэнчин тавьж гэрээ байгуулсан. Чи анх Фа-г олж авахдаа Дафа-гийн шавь нараас Дафа-г энд байгааг дуулсан, тэгээд л чи бясалгаж эхэлсэн, хэн ч чамайг албадаагүй. Хүн бясалгахгүй байж болно, хэдийгээр чи амиараа дэнчин тавьж гэрээ хийж дэлхийд бууж ирсэн ч гэсэн тэр тангаргаа зөрчих эсэх нь мөн чиний хувийн хэрэг, өөр хэнтэй ч хамааралгүй, бясалгах үгүй нь чиний өөрийн хэрэг!

Зарим хүмүүс өөрсдийгөө бясалгагч гэдэг ч бодит байдал дээр бясалгагч хүний хийх ёсгүй зүйлүүдийг хийдэг, мөн тэд “Дафа-гийн шавь” гэсэн нэр хүндийг байнга гутааж байдаг.

Тийм учраас би жинхэнэ бясалгадаггүй, бясалгалын явцад шалгалтуудыг давж чадаагүй, түүндээ гомдоллодог, заналхийлдэг хүмүүст хэлэхэд: Бясалгал бол өөрийгөө бясалгах явдал юм. Чиний хийж байгаа бүх зүйл, тэр дундаа үнэнийг таниулах явцад тэвчиж буй хавчлага зэрэг нь чиний бясалгалын үйл явц бөгөөд заавал хийх ёстой зүйл, мөн хуучин хүчинд албадан хавчигдаж байгаа нь бас өөрийн чинь үйлийн үрээс үүдэлтэй. Эдгээрийн аль нь ч Дафа эсвэл Багшийн төлөө хийгдээгүй, харин чамд нүгэлт үйлийн үр байгаа учраас хуучин хүчний барьж авах шалтаг болдог.

Багш бүх амь бодиудад нигүүлсэнгүй ханддагийн улмаас та бүхний төлөө дэндүү ихийг өөртөө үүрсэн, та нарын бясалгалдаа амжилтад хүрч чадна гэдэгт найдвар тавин маш их зүйлийг хийж өгсөн, энэ бүхнийг хийх л ёстой байсан гэж боддог уу? Зарим нь бүр, Багш та нараас ямар нэгэн ашиг тус хүртдэг гэж боддог. Багшид та нарын төлөө зовлон дааснаас өөр та нараас олж авсан юу ч байхгүй, Багш бүх амь бодиудыг нандигнадаг учраас л үүнийг хийдэг! Бясалгаж амжилтад хүрэх эсэх нь чиний хувийн хэрэг. Орчлон ертөнцийн Фа цэвэрлэгээ аль хэдийн төгсгөлдөө ирээд байна, энэ цаг хугацаа дуусмагц шигших, устгах ноцтой үйл явц болно. Тиймээс өөрсдөө мэдсүгэй! Энэхүү түүхэн үеийг туулж буй Дафа-гийн шавь нарыг Бурхад хүртэл хүндэтгэж байна. Урьд өмнө хэзээ ч байгаагүй хамгийн хэрцгий хавчлагыг даван туулж чадаж байгаадаа өөрсдийгөө бас эрхэмлэх ёстой. Жинхэнэ Гэгээрэгч болцгоогоорой! Гагцхүү үүнийг л Бурхдууд гайхамшигтай гэж үздэг!

Багш Ли Хонжи

2023 оны 8 сарын 31